



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

Үндэсний түшиц байгууллага-БСҮХ

Орон нутгийн хэрэгжүүлэгч



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
БОЛОВСРОЛЫН САН (FEE)-ИЙН
ГИШҮҮН

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН
ТӨВ НҮТБ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

Улирал тутмын цахим сонин

Дугаар №7

2022 оны 2 дугаар улирал

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД:

- “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл-2022” Үндэсний чуулганы тойм
- Байгаль орчны мэдээллийн явуулын анхны төвийг Орхон аймагт байгууллаа
- Тогтвортой хөгжлийн загвар сургуулиудын үзэсгэлэнгээр зочилж
- Үндэсний чуулганы төлөөлөгч багачуудын сэтгэгдлээс
- Мод үрэлгээний талбайтай, эко зуслантай Тогтвортой хөгжлийн загвар сургуулиас хийсэн сурвалжилга
- “Хувьсаж буй боловсрол” хэлэлцүүлгээр 1000 орчим санал гарлаа. Үндэсний хэлэлцүүлгийн тойм
- “Уламжлал нэрээр хүүхдийг эрдэд оруулах нь байж болохгүй үйлдэл” Гаага дахь ОУ-ын Эрүүгийн шүүхийн ахлах өмгөөлөгч Н.Орчлонтой хийсэн ярилцлагаас

РЕДАКЦИЙН ЗУРВАС

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн ТЗЗҮБ-ийн гишүүн байгууллагуудын манлайлал дор “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл-2022” үндэсний чуулганыг Тогтвортой хөгжлийн боловсрол-II /ТХБ-II/ төслийн оролцогч талууд, хэрэгжүүлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь, Монгол Улсын боловсролыг хувирган өөрчлөх нь сэдвийн хүрээнд Орхон, Булган аймагт амжилттай зохион байгууллаа.

Чуулганд ТХБ-II төслийн үндэсний зөвлөн зохицуулах багийн гишүүн БШУЯ, БОАЖЯ, МУБИС, төслийн үндэсний түшиц байгууллага Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, төслийн орон нутгийн түшиц байгууллага БОМСТ ТББ, Боловсролын Ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий

газар, МҮОНРТ болон төсөл хэрэгжиж байгаа зорилтот аймгууд болох Архангай, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн болоод төслийн загвар 30 сургуулийн багш, сурагчдын төлөөлөл нийт 300 гаруй төлөөлөгч оролцлоо.

Тус чуулганы үйл ажиллагааг МҮОНРТ, МОНЦАМЭ, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонин, Unuudur.mn, Gogo.mn, Peak.mn сайт, Орхон аймгийн EBS ТВ зэрэг нийт 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага сурвалжилж, олон нийтэд хүргэсэн юм. Энэ удаагийн цахим сонингоороо тус чуулганы тоймыг сэтгүүлчдийн бэлтгэсэнээр багцлан хүргэж байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын төлөө хамтран ажилладаг, биднийг дэмждэг, харилцан туршлага солилцдог бүгдэд талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

“Тогтвортой хөгжлийн боловсрол”
цахим сонин редакц

Тогтвортой хөгжлийн боловсрол-II төсөл.

ТХБ-ҮЙЛ ЯВДАЛ

байгагүй шинэ ажлын байр угтах аж. 2030 он гэхэд дэлхийн ажил хөдөлмөрийн зах зээлийн 50 орчим хувийг хиймэл оюун ухаантай робот хийнэ. Дэлхийтэй хөл нийлүүлж алхахад тогтвортой хөгжлийн боловсрол ихээ үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс манай боловсролын асуудал эрхэлсэн бодлогын яаманд асар хурдан хувьсан өөрчлөгдөж буй нийгэмтэй уялдуулж, олон улсын чиг хандлагад нийцсэн боловсролын хөгжлийн стратеги боловсруулж багтах, хууль эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ гарч буй. Улмаар тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж буй төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, сайн туршлагыг түгээх шаардлагатай.

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг хэрэгжүүлэх дэмжих түшиц байгууллага БШУЯ, БОАЖЯ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын ЮНЕСКО-ийн Үндэсний комисс, Орхон, Булган аймгийн ЗДТГ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, МУБИС, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, МҮОНРТ, Байгаль орчны мэдээлэл сургалтын төв ТББ, “Амгалан Дэлхий” ТББ-ынхан эл чуулганд нэгджээ.

Чуулганы үеэр Байгаль орчны явуулын мэдээллийн төвийг Орхон аймагт нээж, хэрэгцээтэй тоног төхөөрөмж, тавилгуудыг өгсөн. Орхон аймгийн хэмжээнд 26 сургууль, 39 цэцэрлэгт 30 000 гаруй хүүхэд сурдаг. Ирэх намраас аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, сургуулиудтай хамтраад 30000 хүүхдийг хамарсан эерэг нөлөөллийн ажил эхлүүлэх нь.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭХ ЖИШИГ 30 СУРГУУЛЬТАЙ БОЛЛОО



Д.Мягмаржаргал

Unuudur.mn

Орхон, Булган аймагт болсон “Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл” Үндэсний чуулганы тойм сурвалжилга

Нэгдсэн үндэсний байгууллагаас 17 зорилт дэвшүүлснийг дэлхий нийтээрээ мэднэ. Улс орнууд дор бүрнээ хөгжлийн зорилтоо тодорхойлж, хэрэгжүүлж буй. Монголын төр ч ялгаагүй. Дээрх 17 зорилтын IV-т Чанартай боловсрол олгоно хэмээн эрэмбэлсэн нь бий. Тэгвэл манай улсад “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” (ТХБ-II) төслийг хэрэгжүүлээд цөөнгүй жилийг үдсэн байна. Онцолж тэмдэглэхэд, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд Хэнтий, Ховд, Хөвсгөл, Архангай, Булган, Орхон хийгээд нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийг хамруулж, нийт 30 сургууль боловсролын салбарт жишиг тогтоосон амжилтыг дор бүрнээ гаргасан байна.

Монгол Улс хувьсан өөрчлөгдөж буй боловсролыг судалж, хэлэлцүүлж, улмаар саналаа нэгтгээд ЮНЕСКО-д танилцуулах юм билээ. Үүний хүрээнд

“Тогтвортой хөгжлийн төлөөх хамтын санаачилга, түншлэл-2022” үндэсний чуулганыг зургадугаар сарын 28-30-нд Орхон, Булган аймагт зохион байгууллаа. Тогтвортой хөгжлийн боловсрол олгож буй учраас чуулганы үеэр хуванцар сав ашиглахгүй, зөвхөн орон нутгийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх, хоолоо үлдээхгүй зооглох, дахин боловсруулсан цаасан дээр материалуудаа хэрэглэх, хогоо зориулалтын саванд хаях зэрэг шаардлага тавьж байлаа.



Чуулганы үндсэн илтгэлийг БШУЯ-ны мэргэжилтэн Д.Мянган “Ирээдүйн боловсролын тухай дахин төсөөлөх нь” сэдвээр тавьсан. Олон улсын судалгаагаар өнөөдөр ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн 65 хувийг урьд нь сонсож

Үндэсний чуулган Булган аймгийн Хангал суманд



Дараа нь чуулганы төлөөлөгчид Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаатай танилцсан юм. Мөн чуулганыг зохион байгуулагчид таван салбар хуралдаан зохион байгуулж, багш, сурагчдад Дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт, Тэгш, хүртээмжтэй, аюулгүй, эрүүл сургууль, багшлахуй болон багшийн мэргэжил, боловсролын санхүүжилт, хүүхэд засагладаг сургууль сэдвээр мэдээлэл өгч, хэлэлцүүлэг өрнөсөн. Нэг зүйлийг онцлоход сурагчид салбар хуралдаанаа бие даан зохион байгуулсан. Улмаар хүүхэд нэг бүрчлэн саналаа хэлж, БШУЯ-ны удирдлагад хурлын тэмдэглэлээ хүргүүлжээ.

ГАРЧИГ

ТХБ-ҮЙЛ ЯВДАЛ	1-2
ТХБ-ҮР ДҮН	3
ТХБ-ӨӨРЧЛӨЛТ	4
ТХБ-БУТЭЭН БАЙГУУЛАЛТ	5
ТХБ-ЗОЧИН	6-7
ТХБ-СЭТГЭГДЭЛ	8
ТХБ-ЯРИЛЦЬЯ	9
ТХБ-ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	10



Тогтвортой хөгжлийн төлөөх 30 загвар сургуулийн төлөөлөл ийн ярилаа

Орхон аймгийн Баян-Өндөр сумын 14 дүгээр сургуулийн захирал П.Амгалан “Манай сургууль 2019 оноос “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг хэрэгжүүлсэн. Төслөө өөрсдөө бичиж шалгарсан. Улмаар сургуулийн тогтмол үйл ажиллагааны зардлыг хэмнэх зорилгоор улайссан шилэн гэрлийг халж, бүх анги танхим, өрөөгөө лед гэрэлтэй болгосон. Мөн сурагчдад эрчим хүч хэмнэх энгийн ойлголт өгч, өрөөнөөс гарахдаа гэрэл унтраах дадал суулгасан. Ингэснээр сүүлийн улиралд гурван сая төгрөг хэмнэлээ. Энэ арга туршлагаа төсөлд хамрагдсан 30 сургуулийн удирдлага, сурагчдад танилцуулсан” хэмээв. Мөн тус сургуулийн 12Б ангийн сурагч О.Дорждэрэм “Манай сургууль дунд, ахлах ангийнханд “Электрон жаал” гэсэн сургалт явуулдаг. Ингэснээр цахилгаан эрчим хүч хангамжийн олон талын мэдлэгтэй болсон. Тогтвортой хөгжлийн бодлогоор бага ангиудад ч насанд нь тохирсон хичээл ордог” хэмээн сурснаа хуваалцлаа.

Хэнтий аймгийн Баян-Адрага сумын сургуулийн багш, сурагчид хогоо ангилал, дахин боловсруулах санаачилга гаргахад орон нутгийн удирдлага нь дэмжсэн аж. Ингээд сумын хэмжээний ажил болгоод амжилттай хэрэгжүүлсэн туршлагаа энэ үеэр хуваалцаж, дээрх байдлаар орон нутаг дахь нөлөөлөл хамтын ажиллагаа чухал гэдгийг оролцогчдоо ойлгуулав.

Чуулганы хаалтын үйл ажиллагаа Булган аймгийн Эко зусланд



Уулын энгэр, усны дэргэд, модны захад, хүүхдийн зусланд Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх чуулган үргэлжилсэн юм. Төсөлд Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургууль нутаг орны онцлог байгалийн сайхнаа түшиглэн эко зуслан, сургалтын төв байгуулжээ. Тус зуслангийн анхны амрагч нь чуулганы төлөөлөгч 6 аймгийн 30 сургуулийн хүүхдүүд байлаа. Эко зуслангийн талаар тус тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ “Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилт, Тогтвортой хөгжлийн боловсрол-II төслийг орон нутагт хэрэгжүүлэгч Байгаль орчны мэдээлэл сургалтын төв ТББ-ын зөвлөмж, зөвлөгөөний дагуу эко зуслангаа байгуулж, өнөөдөр ажлын минь үр дүн гарч ашиглалтад оруулсандаа баяртай байна. Зусланг байгуулахад Швейцарын хөгжлийн агентлагт төсөл бичиж анхны эх үүсвэрээ олсон. Дахин дэд төсөл бичиж, нийт 30 орчим сая төгрөгийн санхүүжилт авсан. Үүндээ урамшаад Булган аймгийн ЗДТГ-г хүсэлт гаргаж, 20 сая төгрөгийн дэмжлэг авсан. Мөн Хялганат тосгоны ард иргэд, аж ахуйн нэгжүүд барилгын материалаас авахуулаад сэтгэлээсээ тусалсан. Эко зуслан эрэгтэй, эмэгтэй тусдаа зургаан амралтын байртай. Нэг ээлждээ 48 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай. Сурагчдын зуны амралтаараа экологийн боловсрол олгохоос гадна, монгол ахуйн хичээл орно, гадаад хэлний вакум сургалтад хамруулна. Сурагчдыг хэт их хичээлээр шахахгүй, сүү, цагаан идээ боловсруулахыг харуулж, ахуй соёлоо уламжлуулахад анхаарна. Хүүхдүүд хөдөлмөр хийх биш, үзэж, харж, танилцана. Цаашдаа Булган аймгийн нутаг дэвсгэрийн зүүн хойд бүсийн



сумдын хүүхдүүд амрах боломж бүрдүүлнэ” гэлээ.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар цахилгаан тагаж, худаг гаргах ажил үргэлжилж байна. Эко зуслангийн нээлтийн дараа тогтвортой хөгжлийн 30 загвар сургуулийнхан төсөлд хамрагдаж юу бүтээснээ үзэсгэлэн зохион байгуулж тайлагнасан билээ.

Эх сурвалж: “ӨНӨӨДӨР” сонин

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГООР МОНГОЛ УЛС МАНЛАЙЛАГЧДЫН НЭГ НЬ”

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн Олон улсын зөвлөх Мита Хангия Говсами “Тогтвортой хөгжлийн бодлогын чиглэлээр Монгол Улсыг манлайлагч гэж би үздэг. Үүний нэг баталгаа нь НҮБ-ын ЮНЕСКО-оос гаргасан Тогтвортой хөгжлийн бодлогын арга аргачлалын олон улсын эмхтгэлд орсон Тогтвортой хөгжлийн тэргүүлэх 5 чиглэлийн хоёрт нь Монгол Улс жишиг улсаар нэрлэгдсэн байдаг. Мөн өнөөдрийн чуулганаар хийж бүтээсэн ажлаа нүүр бардам хэлэлцэж байгаа нь бас нэгэн бодит жишээ билээ”.



“ХИЧЭЭЛ СУРГАЛТЫГ ТАНХИМААС ГАРГАЖ БҮЙ ТУРШЛАГЫГ ЭКО ЗУСЛАНГААС СУДАЛЖ БОЛНО”

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн үндэсний зохицуулагч А.Энхтөгтох:

ТХБ-II төсөл үндэсний хэмжээнд чуулга уулзалтаа хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. 2021 оны цахим чуулганаар бид оролцогч талуудын хамтын ажиллагаа, түншлэлийг голлон анхаарч байсан бол энэ жил түншлэл, хамтын ажиллагаа, оролцоог



эрчимжүүлэхэд түлхүү анхаарч байна. Тиймээс оролцогчид, сургуулиуд туршлага судлах, сургуульдаа нэвтрүүлэх, бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлэхэд чиглэж байна. Үндэсний чуулганы танхим, зочид буудалд зохион байгуулаагүй учир нь энэ бүтээсэн болгоныг төлөөлөгчдөд нүдээр үзүүлэх, бодитоор танилцуулах зорилготой. Хичээл сургалтыг танхимаас гаргах санал санаачлагыг бодитой ажил хэрэг болгож буй туршлагыг энэ эко зуслангаас судалж болно.

ТХБ төсөл загвар сургуулиудад жижиг төслөө хэрэгжүүлэхэд нь тус бүр 7.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлдэг. Үүн дээр орон нутаг мөн хэмжээний санхүүжилт олгодог.

“ЗАГВАР 30 СУРГУУЙН БАГШ НАР МЕНТОР ХИЙХ ТҮВШИНД ХҮРСЭН”

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн зөвлөх Д.Хишигбуян:

Үндэсний чуулганы бага чуулган олон талыг оролцуулсан 5 салбар бүлэг хуралдаанаар үргэлжилж саналаа нэгтгэлээ. Цаашид ТХБ-ыг бодлогод хэрхэн тусгаж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, багшийг ТХБ-ын чиглэлээр чадавхжуулахад ямар дэмжлэг үзүүлэх, залуучуудын оролцоог яаж хангах, суралцахуйн хувирган өөрчлөлтийг хэрхэн хийх гэсэн сэдвүүдийг сонгож авч хэлэлцлээ. Хэлэлцүүлгийн гол үр дүнд ТХБ-II төслийн хүрээнд ямар боломжууд бий болов, бид юунд хүрэх, цаашид бид олон чиглэлээр ТХБ-ыг монгол улсад дэмжин хөгжүүлэхэд юу хийж, яаж дэмжиж ажиллахаа ярилцлаа.



Монгол Улс ТХБ-ын зорилго, зорилтыг үндэснийхээ бодлогод баттай суулгаж чадсан нь бидний гол боломж. Өнөөдөр энэ бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад ТХБ-II төсөл хувь нэмрээ оруулсан. Үүний жишээ нь бид өөрсдөө бодлогын түвшиндээ олон зүйлийг хийсэн. Орон нутгийн түвшинд загвар 30 сургуулийн жижиг төслөөр дамжуулан ТХБ-ыг амьдралд хэрхэн хэрэгжүүлэх, багшийн үйл ажиллагаанд хүүхдүүдийн сургалтанд



яаж оруулах тал дээр өнгөрсөн хоёр жилд бодитой ажил өрнүүлж туршлага хуримтлууллаа. Одоо энэ туршлагаа гүнзгийрүүлж, түгээн дэлгэрүүлж сурталчилмаар байна. Үүний тулд орон нутагт түншлэл хамтын ажиллагаагаа сайжруулах саналууд гарч байна. Багш нар бусад сургуульд ментор хийх түвшинд хүрсэн, ийм чадвартай болсон гэдгээ илэрхийлж байна.

“БИД АСУУДАЛ ШИЙДЭХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ ӨГЧ, ТҮНШЛЭЛИЙН ГАРААГ ЭХЛҮҮЛЭХИЙГ ЗОРЬЖ БАЙНА”

“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийг орон нутагт хэрэгжүүлэгч БОМСТ ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Шинэцэцэг:

ТХБ-II төсөл 6 аймаг, 2 дүүргийн ЕБ-ын 30 загвар сургууль дээр хэрэгжиж байна. Сургуулиуд анх төсөл хэрэгжүүлэхдээ сургууль өөрөө бүхлээрээ өөрчлөгдөхийг хүсэж байна уу гэдгээ өөрийн үнэлгээгээр тодорхойлсон. Тэд өөрийн үнэлгээгээр сургуулийнхаа, орон нутгийнхаа тулгамдсан асуудлуудаа илрүүлж гаргаж ирсэн. 30 сургуулийн үнэлгээнд нийт 15 000 орчим хүн оролцсон байдаг. Дараа нь энэ асуудлуудыг өөрчлөхийн тулд юу хийх вэ гэдгээ мөн сургуулийн баг хамтаараа орон нутагтайгаа хэлэлцсэн. Ингэж асуудлыг шийдэх, өөрчлөх тэдний төлөвлөгөө, шинэ санааг ТХБ төсөл дэмжиж жижиг санхүүжилт олгосон. Бидний өгч байгаа хөрөнгө өчүүхэн жижиг хэсэг болохоор бид жижиг төсөл гэж яриад байгаа хэрэг.



Тухайлбал Архангай аймгийн Батцэнгэл нь сум даяараа халуун усны асуудалтай. Энэ нөхцөл байдал нь дотуур байрны хүүхдүүдийн хувийн ариун цэврээс эхлээд олон асуудалд нөлөөлөх хүчин зүйл болж байгаа юм. Тус сумын сургууль үүнийг гаргаж тавьснаар шийдэх санхүүжилтээ ТХБ-II төслөөс авсан. Үүгээрээ бид асуудлыг шийдэх эхлэлийг тавьж, арга зүй, аргачлалыг өгье, түншлэх гарааг эхлүүлж гэж байгаа юм. Бидний өгсөн багахан мөнгө, тэр арга аргачлал 100 сая, 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг бий болгох боломжтой. Энэ бол Тогтвортой хөгжлийн боловсролын зохих чадварууд. Хүнтэй харилцах, хамтрах, бие дааж үйл ажиллагаа явуулах чадвартай байхад ямар ч асуудлыг эерэгээр, зөвөөр шийдэх чадвартай болж байгаа гэсэн үг. Энэ нь бидний бий болгох гээд байгаа Тогтвортой хөгжлийн боловсрол /ТХБ/ юм.



Сургуулиуд удирдлагуудын түвшиндээ ТХБ-ыг тодорхой хэмжээгээр сураад явж байна. Одоо орон нутаг энэ зарчим, менежментийг бусад сургуульд нэвтрүүлж, нутагшуулж өгмөөр байна. Цаашдаа яах вэ гэдгээ аймаг бүр төлөвлөж буй.


Чуулган Хялганатын сургуулийн эко зуслан дээр үргэлжилж байгаа нь төлөөлөгчид, оролцогчдоод “барьцах” хүсэл төрүүлж, “бид ч гэсэн энэ хүрч болох юм байна” гэдэг мөрөөдлийг асааж байна.

Өнгөрсөн хоёр жил ковидын цаг хугацаатай нүүр тулсан учраас ТХБ-II төслийн төлөвлөсөн ажлууд амжсан нь ч байна, амжаагүй ч бий. Тиймээс төслийн үнэлгээний багийнхан ажлаа бүрэн дуусгах боломжийг олгоё гээд тус төслийг нэг жилээр сунгалаа.

Эх сурвалж: MNB.mn

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ЯВУУЛЫН АНХНЫ ТӨВИЙГ ОРХОН АЙМАГТ БАЙГУУЛЛАА

БОАЖЯ, БШУЯ, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтарсан “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд байгаль орчны талаарх цогц мэдээлэл өгөх явуулын төвтэй болох ажлыг эхэллээ.



Энэхүү төсөл нь Орхон, Хөвсгөл аймагт хэрэгжиж байгаа бөгөөд Орхон аймагт байгуулагдсан төв нь байгаль орчны эко системийн талаарх мэдээллийг өгөхөөс гадна, хорхой шавжийн онцлог, усны бохирдлыг хэмжих, хөрсний судалгаа хийх зэрэг бичил туршилтуудыг хийж үзэх боломжийг олгож байгаагаараа онцлог. Мөн виртуал байдлаар тухайн орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтантай танилцах боломжтой.

Эхний ээлжид Орхон аймагт явуулын төв байгуулсан бол Хөвсгөл аймагт танхимаар мэдээлэл өгөх боломжийг олгож байна. Цаашид энэхүү хоёр загвараар бусад аймаг, суманд байгаль орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох төвийг байгуулах боломжтой ажээ.



БОАЖЯ-ны Хэлтсийн дарга Ц.Уранчимэг “ТХБ-II” төслийн хүрээнд нийгэм, байгаль орчин, боловсролд ээлтэй хүргэмжтэй олон төсөл хэрэгжиж байгаагийн нэг нь Байгаль орчны боловсролыг цогцоор өгөх зорилготой явуулын мэдээллийн төвийн төсөл юм. Энэхүү төслийн санхүүжилтийг Швейцарын хөгжлийн агентлаг болон Орхон аймаг орон нутгийн төсвөөсөө шийдвэрлэсэн. Манай яамнаас хөтөлбөр боловсруулж баталж өгсөн” гэв.



“Байгаль орчны мэдээлэл сургалтын төв” ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Шинэцэцэг “Явуулын сургалт мэдээллийн төвийн энэ жилийн үндсэн агуулга нь хөрс, усны асуудал. Усаа таньж мэдээгүй байж эрүүл хоол хүнс, эрүүл орчин нөхцөлийн талаар ярьдаг. Тэгвэл тухайн орон нутгийн иргэдийн хэрэглэж байгаа, мал амьтны ундаалж байгаа усны бохирдол ямар түвшинд байна вэ гэдгийг судалж үзэх, хоёрдугаарт тухайн орон нутгийн хөрс нь ямар онцлогтой, ямар бүтэцтэй байна вэ, тухайн газарт ямар ургамал, мод ургах боломжтой вэ гэдгийг судалж тогтоохыг зорьж байна. Мэдээж нарийн судалгааг хийж чадахгүй. Би тухайлбал хашаандаа ногоо тарих гэж байгаа бол хөрсөө таньж мэдэх хэмжээний хамгийн энгийн багаж хэрэгслүүд энд бий” хэмээв.

Эх сурвалж: Gogo.mn

ЯВУУЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ НЬ 30 МЯНГА ОРЧИМ ХҮҮХДЭД ХҮРНЭ



... Мөн байгаль орчны явуулын мэдээллийн төв нь орчин үеийн техник технологид суурилж, мэдээллийг цахим буюу виртуал хэлбэрээр хүүхдүүдэд үзүүлэх аж. Үүний хүрээнд Орхон аймгийн эдийн засаг, нийгэм, байгаль орчин гэсэн үндсэн гурван чиглэлээр зураг болон бусад бичгэн мэдээллийг Байгаль орчны мэдээллийн явуулын төвдөө оруулжээ. Мөн аймгийнхаа 3D газрын зургийн загварчлалыг хийж, цэгүүдэд бичлэг хэлбэрээр мэдээллийг холбосон байна. Энэ нь хүүхдүүдэд танин мэдэхүйн ач холбогдол өгөх онцлогтой юм.

Эдгээр мэдээллийг “medlee.mn”, болон бусад ЕБС-уудын хамгийн өргөн хэрэглэгддэг сайтад тавих боломжтой юм байна. Түүнчлэн амьтдын хөлийн мөрийг таних хэвэн дээр QR код байршуулна. Ингэснээр тухайн нэр төрлийн амьтад хаагуур нутаглаж байгаа, хичнээн тоо толгой байна гэсэн мэдээллийг харах боломжтой. Хөрс, ус, биологийн төрөл зүйлийн судалгаануудыг газар дээр нь бодитоор хийх боломжтой уг явуулын мэдээллийн төвийн зорилтот хэрэглэгч нь цэцэрлэгийн хүүхдүүд, ЕБС-ийн сурагчид, залуус юм. Мөн бодит сургалтын орчны үндсэн агуулга нь 1-2 жилдээ өөрчлөгдөж байх ёстойг “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн орон нутаг дахь хэрэгжүүлэгч байгууллага Байгаль орчны мэдээлэл сургалтын төв танилцууллаа.

Орхон аймаг нь 110 мянга гаруй хүн амтай. 26 сургууль, 39 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр боловсролын байгууллагад 30 мянга орчим хүүхэд сурдаг байна. Есдүгээр

сараас сургууль бүр дээр хуваарь гаргаад тогтвортой хөгжлийн боловсрол, экологийн боловсрол олгох, сургалт мэдээлэл судалгааны ажлыг БШУЯ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байгаа аж. Энэ нь аймгийн хүн амын гуравны нэгд хүрч мэдээлэл олгох боломж бүрдэхийг мэргэжлийн хүмүүс хэлж байлаа. Мөн аймгийнхаа аж ахуйн нэгж байгууллага, иргэддээ багуудаар дамжуулж, байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлого, экологийн боловсрол олгохоор төлөвлөжээ.



Орхон аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн П.Одончимэг “Орхон аймгийн хувьд газар нутгийн хэмжээ бага, хүн ам их төвлөрсөн, байгаль орчин, ус хөрс агаарын бохирдол сөрөг нөлөөлөл ихтэй. Жил бүр аймгийн хэмжээнд газар, усны тоо бүртгэл зохион байгуулдаг. Нийтдээ 600 гаруй уст цэгийг тоолдог. Худаг, усалтын систем цэвэрлэх байгууламж, хяналтын цооногийн талаарх өөрчлөлт, төлөв байдлыг нь тодорхойлж, аймгийн нэгдсэн мэдээллийн санд оруулдаг. Орхон аймаг 10 жижиг гол, 40 булагтай. 600 гаруй уст цэгийн 500 гаруй нь гүний худгууд бий. Айл болгон нүхэн жорлон, муу усны цооногтой учраас хөрсөөр дамжиж олон төрлийн бохирдол үүсэж байна. Энэ нь иргэдийн төдийгүй эдийн засгийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа учраас шинээр худаг гаргах асуудлыг, хязгаарлах бодлого барьж ажиллаж байгаа” гэлээ.



Байгаль орчны явуулын мэдээллийн төв нь хүүхэд багачуудад багаас нь байгаль дэлхийгээ хайрлах, таньж мэдэх, байгалийн нөөц баялгийг зөв ашиглах, дадлыг суулгах зорилготой. Эх дэлхийгээ хайрлах сэтгэл, экологийн боловсролтой ирээдүйг цогцлоож буй нь Монгол улс тогтвортой, ногоон хөгжилтэй болохын гүүр билээ.

Эх сурвалж: “Зууны мэдээ” сонин 2022 ОНЫ Долдугаар САРЫН 4. ДАВАА ГАРАГ. № 130 (6862)

/Үндэсний чуулганы сурвалжилгийн үргэлжлэл/

Үндэсний чуулганы үеэр шинээр үүдээ нээсэн Булган аймгийн Хялганат тосгоны хүүхдийн Эко зусланд “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд хамрагдсан сургуулиуд өөрсдийнхөө санаачлан хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн гаргалаа. Ширээн дээр янз бүрийн хэлбэр дүрс, өнгөтэй саван, лаа, үнэртүүлэгчийг өржээ. Энэ бол Хөвсгөл аймгийн “Авьяас” сургуулийн хүүхдүүдийн төслийн хүрээнд өөхөн тосоор хийсэн бүтээлүүд. Тус сургууль эрчим хүч, хог хаягдал, хариуцлагатай худалдан авалт, усны хариуцлагатай хэрэглээ гэсэн төсөл хэрэгжүүлж байна.



Хог хаягдлыг дахин ашиглах төслийн хүрээнд өөхөн тосоор бүтээгдэхүүн хийсэн нь сайшаалтай санагдлаа. Хүүхэд сургуулиасаа авсан мэдээллээ гэр бүл дээ түгээдэг. Тиймээс “хүүхдээс гэр бүлд” гэсэн аргачлалаар хөтөч дэвтрэ нээжээ. Дэвтрийг хог хаягдлын хариуцлагатай хэрэглээг багасгахын тулд бүтээсэн. Хүүхэд дэвтрээ ашиглахын тулд гэртээ очоод хогоо хаях нь байгаль дэлхийд ямар хор уршигтай талаар ярина. Эндээс зөв хэвшил эхэлнэ гэж үзжээ. Тиймээс уг хөтөч дэвтрийг нэг айлд гурван сар аялуулахаар шийдсэн байна. Тэгээд гэр бүлээрээ дахин боловсруулах боломжтой материалаа цуглуулсан ч хаана хийхээ мэдэхгүй бэрхшээл тулгарчээ.

Тиймээс долоо хоногийн баасан гарагийг сургууль дээрээ дахивар бүтээгдэхүүн авах өдөр болгож, цааш нь тушааснаар анги бүр хуримтлалын данстай болов.

Тус сургуулийн Х ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд хамрагдсанаар байгаль дэлхийгээ хайрлах, ирээдүйгээ золиослохгүйгээр хамтдаа хөгжих сэтгэлийг төрүүлж өгсөн. Өөрсдөө хийсэн бүтээлүүдээ найзууддаа танилцуулж байгаад баяртай байна. Бид төслийн хүрээнд “Авьяасын урлан” клуб нээж тэр бүр хүмүүс хэрэглэдэггүй өөхөн тосоор саван, үнэртүүлэгч, лаа хийсэн. Нэг саван хийхэд сар гаруй хугацаа шаарддаг. Харин саван бүрэн хагахад гурван сар хэрэгтэй. Өөхөн тосоо хүүхдүүд гэрээсээ авчирдаг. Саван хийхэд өөхөн тос, натрийн шүлт, өнгө оруулагч хэрэгтэй. Мөн саван хийхдээ температурыг нь тохируулах хэрэгтэй. Гэрийнхэн маань их дэмждэг. Ээж бидний хийсэн саванг хараад их бахархсан. Бид энэ ажлаа үргэлжлүүлж бусаддаа түгээхийн тулд доод ангийн дүү нартаа зааж, зөвлөдөг” гэсэн нь бахархуштай санагдлаа.



“ЭЭЖ БИДНИЙ ХИЙСЭН САВАН, ЛААГ ХАРААД ИХЭД БАЯРЛАСАН”



Үзэсгэлэнд монгол түмний өв уламжлал ёс заншлыг агуулсан хувцас, хэрэглэл тавигдсан нь Хэнтий аймгийнхны төслийнхөө хүрээнд урласан бүтээлүүд байлаа. Тус аймгийн Дадал сум төслийн хүрээнд “Онон балжирын есөн бахархал” хэмээдэг нутгийнхаа брэнд бүтээгдэхүүн өв соёлоо хадгалах, түгээн дэлгэрүүлэх зорилготой хөтөч сурагч бэлтгэх ажлыг зохион байгуулжээ. Тиймээс сургуулиаа есөн бахархал бүхий брэнд бүтээгдэхүүнээ байршуулсан байна.



Хэнтий аймгийн Дадал сумын биологийн багш Б.Бямбадэлгэр “Хүүхдүүд, эцэг эхчүүд, нутгийн ард түмэн бахархалт есөн газрынхаа талаар мэдлэг, бусдад тайлбарладаг болгох зорилготой аж. Төслийн хүрээнд судалгаа хийхэд өөрсдөө мэдэхгүй зүйл их байсан. Жишээ нь, малгайны цацраг нарыг билгэддэг зэрэг гээгдсэн олон өв соёл бий. Үүнийг хүүхдүүд мэдэж авч байгаа нь бахархалтай” гэж байсан.



“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн орон нутагт хэрэгжүүлэгч БОМСТ ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Шинэцэцэг “Сургуулиуд анх төсөл хэрэгжүүлэхдээ сургууль өөрөө бүхлээрээ өөрчлөгдөхийг хүсэж байна гэдгээ өөрийн үнэлгээгээр тодорхойлсон. Эндээс жижиг төслийн ажил эхэлдэг. Тэд өөрийн үнэлгээгээр сургууль дээрээ, орон нутагт тулгамдсан асуудлуудаа илрүүлж гаргаж ирсэн. 30 сургуулийн үнэлгээнд 15 мянга орчим хүн оролцсон. Дараа нь энэ асуудлыг өөрчлөхийн тулд юу хийх вэ гэдгээ мөн сургуулийн баг хамтаараа орон нутагтайгаа хэлэлцсэн. Ингэж асуудлыг шийдэх, өөрчлөх тэдний төлөвлөгөө, шинэ санааг “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл дэмжиж жижиг санхүүжилт олгосон. Бидний өгч байгаа хөрөнгө өчүүхэн жижиг хэсэг болохоор бид жижиг төсөл гэж яриад байгаа хэрэг.”



Бид асуудлыг шийдэх эхлэлийг тавья, арга зүй, аргачлалыг өгье, түншлэх гарааг эхлүүлж гэж байгаа юм. Бидний өгсөн багахан мөнгө, тэр арга аргачлал 100 сая, 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг бий болгох боломжтой. Энэ бол тогтвортой хөгжлийн боловсролын зохих чадварууд. Хүнтэй харилцах, хамтрах, бие дааж үйл ажиллагаа явуулах чадвартай байхад ямар ч асуудлыг эерэгээр, зөвөөр шийдэж чадна гэсэн үг. Хялганат тосгоны эко зуслан дээр чуулган үргэлжилж байгаа нь төлөөлөгчид, оролцогчдод ийм зуслантай болох боломжтой юм байна гэсэн хүч өгч байна.

Эх сурвалж: “Зууны мэдээ” сонин. 2022 оны Долдугаар сарын 6. ЛХАГВА гараг. № 132 (6864)

ОЮУНЛАГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ХҮҮХДИЙН ЭКО ЗУСЛАН

П.Амгаланбаяр “Зууны мэдээ” сонин



Сүрлэг өндөр уулс нь алсыг ширтэн дүнхийж, чимээ анирдах уудамд талын салхи сэвшээ. Зуны дэлгэр цаг налайн, байгаль дэлхий ногоон өнгөөр гэрэлтэж, ургамал ногоо халиуран, мал сүрэг тааваараа бэлчих нь амгалан тайван. Энэ бол байгалийн үзэсгэлэнт газар цогцолсон Булган аймгийн Хангал сум дахь Хялганат тосгон. Манай сурвалжлах баг “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд Булган аймгийн Хялганат тосгон хүүхдийн эко зуслантай болж, нээлтээ хийж буй учир тус тосгоныг зорьсон юм. Энэ зусланд амарч буй анхны хүүхдүүд тус төсөлд хамрагдсан 30 сургуулийн төлөөлөл байв.



Зуслангийн онцлог нь тус тосгоны сургуулийн хүүхдүүд зун амрахаас гадна өөрийгөө хөгжүүлэх боломжийг нээжээ. Учир нь хүүхдүүдэд экологийн боловсрол олгох, монгол ахуй соёлтой танилцуулахаас гадна гадаад хэлний вакумжуулсан сургалт явуулах аж. Зуслан зургаан амралтын байртай, нэг ээлжиндээ 48 хүүхэд амрах боломжтой юм байна. Түүнчлэн зөвхөн тус тосгоны хүүхдүүд амрахаас гадна Булган аймгийн зүүн хойд бүсийн хүүхдийн сургалтын төв болгож өргөжүүлэх зорилготой байгаагаар албаны хүмүүс онцолж байлаа.



Мөн аймгийн төвөөс 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж цахилгааны асуудлыг шийдэж өгөхөөр болжээ. Энэ үеэр Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны захирагч А.Сод-Эрдэнэ “Энэ зусланг байгуулахын тулд Швейцарын хөгжлийн агентлагт төсөл бичиж, 30 орчим сая төгрөгийн санхүүжилт авсан. Мөн аймгийн төсвөөс 20 сая төгрөгийн дэмжлэг авсан. Хүүхдийн эко зуслан барихад олон хүний сэтгэл, хөдөлмөр шингэсэн гэдгийг онцлох хэрэгтэй. Манай тосгоны иргэд хайрга чулуу, мод буулгаж өгөх, хашаа барихад материалаар тусалсан. Тиймээс хүмүүсийн хөдөлмөрийг мөнгөөр үнэлэхийн аргагүй” гэсэн юм. Хүүхдүүд зун амрахаас гадна өөрийгөө хөгжүүлэх, олон найзтай болох боломж нээгдсэн нь сайшаалтай санагдалаа. Эх орныхоо баруун зүг буйдхан талд орших Хялганат тосгоны бүтээн байгуулалт нь бусдад үлгэр дууриал болохуйц оюунлаг бүтээн байгуулалт болсныг нээлтэд оролцсон хүмүүс онцолж байлаа.

“Зун үр бүтээлтэй амрах боломж бүрдсэнд баяртай байна”



“Амрангаа хөгжих боломжийг бүрдүүлж өгсөнд баяртай байна” хэмээн инээмсэглэх охиныг А.Цацрал гэдэг. Тэрбээр “Би Хялганат тосгоны Х ангид сурдаг. Манай нутаг хүүхдийн эко зуслантай болсонд баяртай байна. Байгалийн сайханд амарч, олон найзтай болно гэхээр гоё санагдаж байна. Мөн сагс, гар бөмбөг тоглох боломжтой элсэн талбай хийсэн нь таалагдлаа. Найзуудтайгаа олон дурсамж бүтээж, хүсэл сонирхлоо илүү хөгжүүлж суралцана” гэж байлаа.



Тус зусланд англи хэлний багшийн нэгээр ажиллах эмэгтэйд Н.Халиунаа гэдэг. Хялганат тосгоны уугуул тэр англи хэлний багш мэргэжлээр их сургуулиа төгсөж нутагтаа ирж ажиллаад дөрөв дэх хаврыг үдэж байна. Тэрбээр “Олон хүний хүч хөдөлмөр шингэсэн хүүхдийн зуслан үүдээ нээж буйд баяртай байна. Хэд хоногоос зуслангийн анхны амрагч хүүхдүүдээ хүлээж авна. Энэ гэгээн үйлсэд оролцож, мартагдашгүй цаг хугацааг бүтээж буй нь багш мэргэжил эзэмшсэний минь бахархал. Эхний ээлжийг англи хэлний хөтөлбөрөөр эхлэх төлөвлөгөө гаргасан. Өдөрт 4-6 цаг орох хэдий ч хүүхдүүд амарч бусадтайгаа тоглонгоо суралцах нь том давуу тал. Хичээлээ заахдаа ямар ч самбар, шохой ашиглахгүй гэдгээрээ онцлог. Уул, ус модыг англиар хэлж, орчинд нь хичээл орохоороо давуу талтай. Мөн тухайн газар ямар жимс ургадаг, ямар онцлогтой, газар нутгийн байршил гэсэн суурь мэдлэгийг давхар олгох юм. Манай сургуулийн багш, ажилчид нэг хүсэл тэмүүлэл зорилготой хамт олон. Тиймээс сайн дураараа зусланд ажиллахаар болсон. Энэ нь хүүхдүүдтэйгээ давхар хөгжих боломжтой” хэмээлээ.



ЭКО ЗУСЛАН ЭХНИЙ ЭЭЛЖИЙН ХҮҮХДҮҮДЭЭ ХҮЛЭЭЖ АВЛАА

Энэ тухай Хялганат тосгоны сургуулийн багш нар өөрийн нүүр номондоо бичжээ. “Эко зуслангийн 1-р ээлж 11-13 насны амрагч хүүхдүүдээ авлаа. Хүүхдүүд

- Ширээний теннис
 - Агаарын теннис /Бадимтон/
 - Элсний волейбол
 - Сагсан бөмбөг
 - Шагар
 - Даамны дугуйлангаар хичээллэнэ. Мөн англи хэл, математикийн сонирхолтой сургалт, хүүхэд хөгжлийн олон ч хөтөлбөр хэрэгжинэ.
- “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл гэсэн байна.



МОД ҮРСЭЛГЭЭНИЙ ТАЛБАЙТАЙ, ЭКО ЗУСЛАНТАЙ, 1000 ЦЭЦЭГТЭЙ ХЯЛГАНТЫН СУРГУУЛЬ

Болд.Б
192@montsame.mn



Улаанбаатар /МОНЦАМЭ/. “Тогтвортой хөгжлийн төлөөх хамтын санаачилга, түншлэл-2022” үндэсний чуулганы үеэр тус тосгоны ЕБС дөнгөж байгуулаад байгаа Эко зуслан, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Тогтвортой хөгжлийн боловсролын төслийн хүрээнд 10 мянган модны үрсэлгээ тарьж, сургуулийнхаа дэргэд ойн зурвас бүхий талбайтай болж буйгаа чуулганд оролцогчдод танилцууллаа.

Сургуулийн захирал Ц.Цолмонбаатартай ярилцлаа.



-Ойн талбайтай болох санаачилга анх яаж гарав?

-Анх бид Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд зуслантай болох гээд “Эко зуслан” гэсэн төсөл бичээд шалгарсан. Зуслан байгуулах явцад өөрийн үнэлгээг хийлгээд ирэхээр бусад зүйлийг хийх шаардлагатай нь харагдсан. Ингээд сургуулиараа ярилцаж олон төрлийн ажил төлөвлөсний нэг нь ойжуулах, хүүхдүүдээ байгаль орчноо хамгаалах, эх дэлхийгээ хайрлаж сургах үүднээс мод тарьж эхэлсэн.



Туршилтын талбайд жимс, ногоо яг боловсрох үеэр хүүхдүүдийн маань амралт таарч ургалтын талаар таниулах аргагүй байсан. Өвлийн хүлэмжгүй учир. Тиймээс жилийн 4 улирал арчилж таниулахын тулд модыг сонгож тарих нь зөв юм байна гээд ойн талбайтай болж эхэлсэн. Үүнийгээ байгалийн ухаан, биологи, газар зүйн зэрэг хичээлд сурагчдад таниулах байдлаар мөн ашигладаг. Манайх бас туслах аж ахуйтай болох гээд зөгийн аж ахуй эрхлэх төсөл бичсэн. Одоохондоо хараахан хэрэгжиж амжаагүй байна.



-Танай талбайд хэдэн төрлийн мод ургаж байна?

-Гацуур, жимсний болон гоёлын гээд 10-аад төрлийн мод тарьж байна. Бид дандаа үрээр нь тарьж байгаа. Намар үрийг нь түүж аваад хавар, намартаа тарьдаг. Мод бүрд таарсан, өөр өөр хөрс сонгон тарьж байна. Энд одоо 10 мянган модны үрсэлгээг ургуулж байна.



-Мод тарьж, ойн талбайтай болоход тодорхой хэмжээний санхүүжилт шаардагдана. Үүнийг яаж шийдэж байна вэ?

-ТХБ-II төслөөс болон аймгаас өгсөн тус бүр 7.5, нийт 15 сая төгрөгөөр эхлүүлсэн. Яг юмаа хийгээд явахаар орон нутгийн, төрийн байгууллага, иргэд, эцэг эхчүүд, хувийн байгууллагууд дэмжээд ирдэг юм байна. 2 куб банз өгөх зэргээр дэм дэмээрээ тусалдаг. Нийтдээ 50 орчим сая төгрөгийн өртөгтэйгөөр, хамт олны хүч хөдөлмөрөөр хүүхдийн эко зуслантай, ойн талбайтай болоод өнөөдөр нээж байна. Бусадтай туршлагаа хуваалцан ярьж таниулж, ойлгуулсны хүчинд мөн энэ бүхэн бүтэж байгаа юм. Аймаг, орон нутгаас бодлогоор дэмждэг.

-Мөн танай сургуулийн коридор, анги танхим бүгд дүүрэн цэцэгтэй харагдана. Сургууль дотроо эко, ногоогий орчинг бүрдүүлэхийг зорьжээ гэж харлаа.

-Тийм ээ. Энэ бүх цэцгийг багш, сурагчид хамтарч тарьж, арчилж ургуулдаг. Бүх анги танхимын цэцгийг нэмэхээр 1000 дөхөх байх. Анги танхимын агаарыг цэвэршүүлээд зогсохгүй, сургалтын хэрэглэгдэхүүн болдог. Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны дунд сургууль нь 620 сурагч, 70 багш, ажилтантай аж.

Үндэсний чуулганы завсарлагаанаар...
“Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх хамтын санаачилга, түншлэл-2022”
“Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөл





“ШИНЭ ЭХЛЭЛ” СУРГУУЛИЙН СУРАГЧ О.ЕРТӨНЦ:

People. The most memorable part was the friends i made along the few days i spent on eco camp (too few i wanna add, but still entertaining). I deeply connected and be friended someone in such a short time i fell in shock, because i never ever done that. We made a group chat and chatting on that. Group chat and chatting on that at the same time as i writing this. Im so soo glad i am the one who chosen to be a representation of my school (to me, i have done a pretty good job) which gone to the camp.



ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ СУМЫН ЕБС-ИЙН СУРАГЧ М.АЛТЖИН:



Энэ хугацаа амьдралын минь мартагдашгүй нэг хэсэг болж үлдсэн. Хамгийн анх хол газар удаан явна гэхээр таагүй санагдаж танихгүй хүүхдүүдтэй ч эвгүй байсан. Гэвч Эрдэнэтээс хөдлөх төдийд надтай санаа бодол, байгаа байдал ойролцоо хүүхдүүдтэй шууд л танилцчихсан. Тэр үед яг зан чанар таарсан хүүхдүүдтэйгээ харилцаад явья гэж бодсон ч ааш зан байгаа байдлыг харалгүй нэгнээ ойлгон найзалж сүүлийн өдөр гэхэд бүгд л их дотно болсон байсан. Олон өөр газраас ирсэн, олон өөр ертөнцтэй хүүхдүүд ингээд яг л хамт олон жил амьдарсан юм шиг л болсон байсан нь сонин. Бас олон өөр ёс заншил, өв уламжлал, зан араншинтай хүүхдүүд болохоор суралцах зүйл маш олон байсан. Дахиад хамт хэдхэн хоносон бол гэдэг бодол бид бүгдээс ер салаагүй. Бүгд хурдан явмааргүй байсан болохоор автобусны ард дотор муу байна гэж хэлээд удаан явуулах талаар ч бүгд бодсон. Гэхдээ цаашдаа илүү олон удаа уулзахыг найдан салахаас өөр арга бидэнд байгаагүй. Ирээдүйд хэн нэгийг нь орхигдуулахгүй бүгд хамт дахин цуглахыг хүсэж байна. Аз жаргалтай 2 хоногийг бэлэглэсэн найзууд, багш нартаа ч үнэхээр их баярлаж байна.



ЗУРГААН АЙМГИЙН 30 ӨӨР СУРГУУЛИЙНХ Ч ГЭЛЭЭ НЭГ АНГИЙН 60 АНД НАЙЗ ШИГ...

Архангай, Булган, Орхон, Хөвсгөл, Хэнтий, Ховд аймагт ТХБ-II төслийн загвар 30 сургууль бий. Дээр нь зочин сургуулиудын хүүхдүүд гээд нийт 60 гаруй хүүхэд залуус багш, сургуулийн удирдлагуудтайгаа ТХБ-II төслийн үндэсний чуулганд оролцлоо. Тэд “гуравхан хоног хамт байсан ч 30 хоносон юм шиг, 6 аймгийн 30 өөр сургуулийнх ч гэлээ нэг ангийн 60 анд найз шиг гоё байлаа. Найзуудаасаа, багш нараасаа, ТХБ-II төслийн ах эгч нараас их зүйлийг сурч мэдлээ. Хамтдаа сайхан аялалаа...” гэсээр гэр гэртээ харьсан. Гэртээ харьж амжаагүй байхдаа сэтгэлийнхээ үгийг цахимаар, нүүр номоороо хуваалцжээ.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЕБС-ИЙН Т.ЖАРГАЛЗАЯА:

Сайн байна уу. Намайг Жаргалзаяа гэдэг. Би Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумаас ирсэн. Анх хүүхдүүд маань нээлийн үйл ажиллагаа энэ тэр дээр нэг нэгэнтэйгээ нээх сайн дотно биш байсан. Тэгээд нэгнийгээ сайн танихгүй байж байгаад зуслан дээрээ ирээд бага багаар танилцаж дотно болж эхэлсэн. Би анх хүүхдүүдээ хараад нэгэнтэйгээ уусаж найзалж чадах болов уу даа, угаасаа өөр өөр газраас ирсэн, өөр өөр зан ааштай хүүхдүүд таарч тохирохгүй байх гэж бодоод нэг их нийлээчгүй. Тэгсэн харин ч эсрэгээрээ зуслангийн багш нар болон бусад хүүхдүүдтэйгээ маш хурдан дотносож байсан. За бас манай зуслан бол үнэхээр гоё байгальтай найрсаг харилцаатай багш, ажилчидтай тохилог орчинтой төсөөллөөс хамаагүй илүү байсан.

Мөн найзууд, ах эгч нартаа маш их дассан байсан. Яг явах гээд салсан чинь цаанаасаа л нэг их сонин болоод нулимс цийлэгнээд бүр нэг салмааргүй, дахиад хамт байгаад баймаар санагдсан даа. Энд ирсэндээ би хэзээ ч харамсахааргүй. Инээд хөөр, баяр баясал дүүрэн дурсамжтай, мартагдашгүй сайхан өдрүүд өнгөрлөө.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН ДЭЛГЭРМӨРӨН ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН 11-Р АНГИЙН СУРАГЧ А.НЯМЖАРГАЛ:

Юуны өмнө миний сэтгэгдлийг уншиж буй хүмүүсдээ тухайн цаг үеийнх нь мэндийг дэвшүүлбэ. Миний хувьд анх гэрээсээ гарахдаа хурдан л буцаж ирэхийг хүсэж байсан. Учир нь тэнд ямар зан ааштай хүүхдүүд очих бол гэдгээс ямар орчин хүлээж байгаа бол гэдгээс санаа зовж байсан. Харин очсон чинь үнэхээр хөөрхөн хүүхдүүд, эко зуслан маань бид бүгдийг хүлээгээд байж байсан. Эхэндээ 1 л бишүүрхээд байсан. Тэнд ирсэн хүүхдүүдийг хараад хурдан дотносохыг хүсэж билээ. Бүгд л тийм нийтэч, хөгжилтэй, муухай зан байхгүй, яг л байгаагаар минь хүлээж авсан нь үнэхээр надад таалагдсан. Зуслан дээр олон гоё үйл ажиллагаанууд зохиогдсон. Үүгээрээ дамжуулан найзуудтайгаа дотносох боломж олдсон. Мөн чуулганд суухдаа баг болоод баг тус бүр нэг, нэг сэдвийн хүрээнд ярилцсан. Ярилцахад үнэхээр таатай байсан. Мөн тухайн хүүхдийн үзэл бодлоор нь дамжуулаад илүү дотносож, бие биенээсээ олон зүйлийг мэдэж ойлгосон. Надад хамгийн их таалагдсан зүйлс гэвэл бид бүгдийг үнэхээр сайхнаар угтаж авсан явдал. Тогтвортой хөгжлийн боловсрол 2 төслийн чуулганд оролцсоноороо олон хүүхдүүдтэй уулзаж, танилцаж найзууд болсондоо баярлаад баярлаад ханахгүй байгаа. Олон сайхан дурсамжийг бүтээлцсэн бүх хүмүүстэй баярлалаа. Хайртай шүү.

БҮХ ХҮҮХДҮҮДДЭЭ БҮР ОЛУУЛЛАА БОЛЖ ДАХИН УУЛЗАХЫН ЕРӨӨЛ ӨРГӨӨ.



УЛАМЖЛАЛ НЭРЭЭР ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛД ОРУУЛАХ НЬ БАЙЖ БОЛОХГҮЙ ҮЙЛДЭЛ

Хуульч Наранцэцэгийн Орчлон Монгол Улсаас анх удаа Нидерландын Гаага дахь Эрүүгийн хэргийн шүүхэд өмгөөлөгчөөр ажиллаж байгаа нэгэн. 2017 онд ахлах хуульч (Counsel P-4) болж, Ази, Африк, Европ хуульчдаас бүрдсэн баг удирдан ажиллаж байна.

Түүнийг Монголоо энэ долдугаар сард ирээд байхад нь Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клубын гишүүд “Өглөөний цагийг өөртөө” уулзалтандаа урьж, ярилцлаа. Ярилцлагаас товчлон хүргэе.



Та өөрийнхөө ажилладаг Гаага дахь Эрүүгийн хэргийн шүүхийг хараат бус гэдгийг хэрхэн тодорхойлох вэ?

Миний ажиллаж байгаа шүүх хараат бус, чөлөөт шүүх. ОУ-ын шүүх улс төржих ёсгүй, ямар нэгэн байдлаар дайны үед хэн нэгний талд орох ямар ч үндэслэл байхгүй. Одоогийн байдлаар ОУ-ын шүүх бол тусгаар улсууд нэгдэж ордог ОУ-ын байгууллага. Нийт 120 гаруй гишүүн улстай. Монгол улс ОУ-ын Эрүүгийн шүүхийн Ромийн дүрмийг соёрхон баталсан эхний 30 орны нэг.

ОУ-ын шүүх нь ямар нэгэн улсаас санхүүждэггүй. 120 улсын Засгийн газраас яг адилхан санхүүждэг. 120 улсын Засгийн газар хуралдаад санал өгч сонгуулиар шүүгчээ нэг удаа 9 жилийн хугацаатай томилдог. ОУ-ын шүүхийн 18 шүүгч, ерөнхий прокурор бий. Америкчууд шүүгч, прокуроруудыг томилоод байгаа гэсэн үг биш. Шүүхийг бүрдүүлж байгаа бүх улсын төлөөлөл адил тэнцүү байдлаар томилогддог. Нэг улсаас нэгээс илүү шүүгч ордоггүй. Ази, африк, латин америк гээд маш олон орноос ирсэн шүүгчид бий. Шүүхийн үйл ажиллагаа өөрөө маш шударга байх ёстой. Шүүхийн өмгөөлөгч бүх улс орноос ирсэн хараат бус өмгөөлөгчид.

Миний тухайд хохирогчийн өмгөөлөгчөөр ажиллаж байна. Шүүх дээр хэрэгт холбогдож ирсэн сэжигтэн өөрийнхөө өмгөөлөгчийг өөрөө сонгох эрхтэй. Шүүх дээр өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхтэй өмгөөлөгчдийг жагсаагаад гаргачихсан байдаг. Ер нь ямар ч шүүхийн эцсийн зорилго хэргийн үнэн мөннийг тогтоох явдал. ОУ-ын Эрүүгийн шүүх бол хүний эрхийг байж болох дээд хэмжээнд нь хангаж ирсэн. Яллах талаас 3 жил нотлох баримт танилцуулвал өмгөөлөх талаас мөн 3 жил танилцуулах боломжтой. Яллах, өмгөөлөх тал аль аль нь нотлох баримтаа 100 хувь гаргаж тавьж байж сая шүүх шийдвэрээ гаргадаг. Яг адилхан нотлох баримтаа танилцуулах эрхтэй байдаг. Бүхэл бүтэн улс орон, олон сая хүний эрх ашгийг зөрчсөн хэрэг дээр аль аль нь нотлох баримтаа 100 хувь танилцуулах эрхтэй.



Манайд сүүлийн үед улс орны томоохон бүтээн байгуулалт, ажлууд дээр цэргүүдийг татан оролцуулах санал, шийдвэр гаргадаг болсон. Энэ байдал хүний эрхийг зөрчих үү?

Энэ бол цалин хөлсгүй мөлжлөг болно. Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлсөө тохирох нь хөдөлмөрлөх эрхээ эдэлж байна гэсэн үг. Цэрэг тушаалаар ажиллаж байгаа нь XXI зуунд хүнийг хүчээр хөдөлмөр эрхлүүлж буй байж болохгүй асуудал. Цэргийн албанд тагагдсан залуус гэмт хэрэг үйлдээд эрхээ хасуулсан хүмүүс биш биз дээ. Өөрөө саналаараа ажиллаагүй. Түүнд цалин хөлсөө сонгох, хамгарсан, гарцаарчилсан гэрээ байгуулах ямар ч эрх олгогдохгүй. Хүний эрх гэдэг нь бидний хэллэгээр маш ариун дагшин зүйл. Үүнд хамаагүй хүрч, түүнийг



хязгаарлаж болдоггүй. Хүн төрөлхтөн үүсэл хөгжлийнхөө явцад олсон зөрчиж болохгүй ариун дагшин, хамгийн нандин эд.

Та яг наадмын үеэр ирлээ. Сум, аймаг, улсын наадам болж буй энэ цаг үед хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудал тулхуу яригддаг. Үүнд таны байр суурийг мөн сонирхъя.

Морь унах бол мэргэжлийн ажил. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ёстой. Хөдөлмөрийн гэрээг насанд хүрсэн иргэнтэй хийдэг. Амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдлийг насанд хүрсэн хүн өөрөө сайн дураараар хүлээн зөвшөөрч цалин урамшуулал авч хийдэг ажил. Морин уралдаанд мөрийг насанд хүрсэн мэргэжлийн хүмүүс унадаг. Гэтэл манайд хүүхдүүд өөрсдөө унаа гээд байгаа гэж зарим нь тайлбарлах нь бий. Хүүхэд аав ээж, бусдыг баярлуулахын тулд юу ч хийхээс буцахгүй. Хүүхэд өөрийн гэсэн мэдлэгтэй, мэдээлэлтэй байж шийдвэр гаргах эрх зүйн чадамжгүй шүү дээ. Тэгвэл 12 настай хүүхэд чихэр өгч хүчиндчихээд “энэ хүүхэд чинь өөрөө үгүй гээгүй ш дээ. Дуртай л байсан юм шиг санагдсан ш дээ” гэх үү. Хүүхэд бэлгийн харьцаанд орох эсэхэд хариулт өгөх чадамжгүй. Юу хийж байгаагаа мэдэхгүй, ойлгохгүй, ухаарахгүй. Тэгэхээр уламжлал нэрээр хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлд оруулах энэ үйлдэл XXI зуунд байж болохгүй үйлдэл. Дэлхийн маш олон орон ийм бурангуй уламжлалаасаа татгалзаад цааш хөгжөөд явж байна.



Тухайлбал Испани улсад бух алдаг нэг төрлийн уламжлал байсан. Гэтэл өнөөдөр энэ уламжлалаасаа татгалзаж хориглосон. Орчин үеийн хүн төрөлхтөн өөрсдийн зугаа цэнгэлийн төлөө амьтан тамлаж алах нь ёс зүйгүй, гэмт хэрэг гээд татгалзаж байна. Гэтэл хүүхдийн эрхийг амьтны эрхээс дор үзэж болох уу.

Хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх зүйн чадамжгүй хүүхдүүдээр морь унуулаад уламжлал гэж тайлбарлаж байгаа нь байж болохгүй асуудал. НҮБ хэзээ ч үүнийг зөвшөөрөхгүй. Морин уралдаан бол дэлхийн хаана ч байдаг спорт. Морь унадаг жижиг биетэй хүн хаана ч байдаг шүү дээ. Би морин уралдааны талаар сайн мэдэхгүй. Гэхдээ асууя. Хүүхэд мориноосоо унадаг уу, моринд дайруулдаг уу, гэмтэж бэртдэг үү? Тийм бол жаахан хүүхдүүдээр морь унуулаад уралдуулаад байдаг миний хувьд бол ямар их хатуу зүрх сэтгэл вэ л гэж хэлнэ. Энэ бол хөдөлмөрлөх эрхийн асуудал. Насанд хүрсэн хүнийг өөрөө хүсээгүй байхад хөдөлмөр хүчээр эрхлүүлэх нь гэмт хэрэг, боолчлол.



Дотоод, гадаадад өрнөж буй улс төрийн, нийгмийн асуудал, үйл явцтай холбогдуулан манайхан үзэл бодлоо янз бүрээр илэрхийлдэг. Дайн самуунтай холбогдуулан үзэл бодлоо илэрхийлж талбай дээр ч жагсаж байна. Гэтэл зарим нь эрхээ хэтрүүлж байна гэхчлэн шүүмжилдэг.

Ардчилсан нийгэмд буруу үзэл бодол, туйлын үнэн, туйлын зөв гэж байхгүй. Хүмүүс өөрсдийнхөө эрх ашгийг зөрчигдөө гэж үзэж байгаа бол үзэл бодлоо илэрхийлэх, жагсах эрхтэй. Туйлын зөв гэж гараад ирэхээр л дарангуйллын нийгэм болж байгаа юм. Сая би ажиглаж байлаа. Бахархлын өдрүүдээр талбай дээр бэлгийн цөөнх жагсаад байна, автобусан дээр үгээ наагаад байна, эрхээ давруулж эдлээд байна гэх зэргээр шүүмжилсэн. Би, та өөрийнхөө эрх ашгийг хөндөгдөхөд талбайд, автобусанд үзэл бодлоо илэрхийлж болж байхад яагаад тэд болохгүй гэж. Энэ бол байж болохгүй зүйл. Хэн ч жагсах, үзэл бодлоо илэрхийлэх адил тэгш эрхтэй. Нэр хүнд, ажил, албан тушаал, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахгүй гэдэг нь энэ юм.



Хүн өөрийнхөө эрхийг эдэлж байгаа нь бусдад заавал таалагдах албагүй. Нийгэм хэзээ ч нэг бүлэг, нэг хэсэг хүмүүст таалагдах боломжгүй.

Баярлалаа.

Тогтвортой хөгжлийн төлөө сэтгүүлчдийн клуб.

“ХУВСАЖ БУЙ БОЛОВСРОЛ” ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР 1000 ОРЧИМ САНАЛ ГАРЛАА

ПАМГАЛАНБАЯР

Өдөр ирэх тусам хувьсан өөрчлөгдөж буй техник технологийн дэвшил хүмүүсийн ахуй амьдралд олон өөрчлөлт, шинэчлэлт хийх хөшүүрэг болж байна. Нийгмийн хөгжлийн хамгийн чухал эд эсийн нэг болох боловсрол хувьсан хөгжих асуудлыг дэлхий нийтээрээ ярьж буй. Тиймээс Монгол Улс НҮБ-аас зарласан, ирэх есдүгээр сард болох “Хувьсаж буй боловсрол” сэдэвт дээд хэмжээний чуулга уулзалтад бэлтгэх зорилгоор хэлэлцүүлгийг 7 дугаар сарын эхээр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт БШУЯ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, НҮБ-ын суурин зохицуулагчийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын дэмжлэгтэйгээр үе шаттай өрнөж байна. Уг хэлэлцүүлэг нь ирээдүйн боловсролыг дахин төлөвлөх, тогтвортой хөгжлийн зорилт дөрвөн үзүүлэлтийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурлагын хоцрогдлыг арилгах, бодлого чиглэл, арга замыг талуудын оролцоотой тодорхойлох зорилготой аж.

“Хувьсаж буй боловсрол” хэлэлцүүлгийг өнгөрсөн 6 сарын 16-29-нд зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт эрдэмтэн судлаачид, хүүхэд залуус, “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төсөлд хамрагдаж буй зургаан аймгийн 30 сургуулийн багш, удирдлага, хэвлэл мэдээлэл, бизнес эрхлэгч, иргэний нийгмийн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл 500 орчим хүн оролцожээ. Тэд дижитал суралцахуй ба хувирган өөрчлөлт, тэгш хүртээмжтэй, аюулгүй эрүүл сургууль, амьдрал, ажил хөдөлмөр, тогтвортой хөгжлийн төлөөх суралцахуй ба ур чадварууд, багш, багшлахуй болон багшийн мэргэжил, боловсролын санхүүжилт сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Харин “Хувьсаж буй боловсрол” сэдэвт нэгдсэн хэлэлцүүлгийг өчигдөр зохион байгуулсан юм. Энэ үеэр мэргэжилтнүүдийн байр суурийг сонслоо.

Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа: Хичээлийн хоцрогдол нөхөх төлөвлөгөө хэрэгжүүлж байна



-Парист өнгөрсөн сард “Хувьсаж буй боловсрол” сэдэвт урьдчилсан хэлэлцүүлэг болсон. Энэ үеэр тухайлсан улсуудад боловсролын шинэчлэлийн асуудал гэхээс илүү боловсролыг хувьсан өөрчилж, цэгцлэхэд юуг анхаарах хэрэгтэйг түлхүү ярьсан. Манай улсын хувьд боловсролын цахим шилжилттэй холбоотой асуултууд дээр түлхүү оролцсон. Ялангуяа, цар тахлын үеийн цахим сургалт, дижитал шилжилтүүдийн талаар танилцуулсан. Бусад улстай харьцуулахад цахим шилжилтийн талаарх туршлага хуримтлуулсан нь тодорхой хэмжээний амжилт үзүүлсэн гэдгийг ЮНЕСКО-ийн олон улсын хурлаар онцолж байсан. Мөн манай улс хичээлийн хоцрогдол нөхөх төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа.

Гэхдээ хичээлийн хоцрогдол арилгахын тулд зөвхөн сурах бичиг, гарын авлага нэмж хэвлээд шийдэх зүйл биш. Багш нартаа тасралтгүй дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Мөн хүүхдүүд бие даан суралцаж, хоцрогдлоо нөхөх технологи, цахимд суурилсан хувилбарт боломжийг нэмэхээр ажиллаж байна. Мөн гүйцэтгэлд суурилсан үнэлгээг явууллаа. Энэ нь хэн,



хаана ямар байдлаар хичээлийн агуулгаас хоцорч, багшид ямар дэмжлэг хэрэгтэй байгааг гаргасан. Ялангуяа, ирэх хичээлийн жилд аль түвшинд илүү анхаарч ажиллах шаардлагатайг судалсан. Тиймээс хүүхэд, багш, сургууль аймаг, сумдад тохирсон ажлаа хэрэгжүүлэх суурь мэдээлэл хангалттай цуглуулж чадсан. Хувьсаж буй боловсрол урт хугацаанд хэрэгжүүлэх алсын хараатай үйл ажиллагаа. Зөвхөн Монгол Улс биш дэлхий даяараа хувьсан өөрчлөх шаардлагатайг цар тахлын нөхцөл байдал, байгаль дэлхий, уур амьсгалын өөрчлөлт харуулж байна. Үүний дараа үндэсний хэмжээний хэлэлцүүлэг өрнүүлнэ. Мөн олон улсын түвшинд санаачлагуудыг дэвшүүлэх уулзалт есдүгээр сарын 19-нд Нью-Йорк хотод болно. Үүнээс гарсан санаачлагууд бүх улсад боловсролын чиглэлээр юу хийх шаардлагатайг тодорхойлно гэсэн үг.



НҮБ-ын суурин зохицуулагч Татан Мишра: Дижитал технологид суурилсан шилжилтийг нэвтрүүлэх хэрэгтэй

-193 орон хэлэлцүүлгийн үеэр гарсан үр дүнгээ танилцуулна. Эндээс бид юуг харахыг хүсэж байна гэвэл Монгол Улс дэлхийд өөрсдийгөө жишиг болгох хэмжээнд боловсролын салбар дахь шилжилт өөрчлөлтийг үр дүнтэй хийснээрээ хүүхэд, залуучуудад ялангуяа, ирээдүйн иргэдийг төлөвшүүлэх юм. XXI зууны шаардлагад нийцсэн сургалтын системийг боловсруулсны үр дүнд ирээдүйн тогтвортой, хүртээмжтэй боловсролын хөгжлийг бий болгоход хувь нэмрээ оруулна. Монгол Улс дэлхийн хэмжээний боловсролд хүрэхийн тулд дижитал технологид суурилсан шилжилтийг нэвтрүүлэх хэрэгтэй. Монгол Улсад давуу талууд



байна. Жишээлбэл, E-mongolia системийг бий болгосон. Цар тахлын үед хүүхэд бүрт хүртээмжтэй боловсролын системийг хэрхэн хүргэх вэ гэдэгт анхаарч ажилласан. Хоёрдугаарт, боловсролын хүртээмж дээр анхаарч ажиллах хэрэгтэй. Ялангуяа, хөдөө орон нутагт байгаа малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд боловсролыг хэрхэн тэгш хүртээмжтэй хүргэх вэ гэдгийг ярилцах ёстой. Нийгмийн гарал үүсэл, статуст боловсролын үйлчилгээг хэрхэн хүртээмжтэй бүрдүүлэх вэ гэдэгт анхаарлаа хандуулах учиртай. Гуравдугаарт, боловсролын хөтөлбөрөөс хүүхэд, залуучууд оюуны мэдлэг боловсролыг аваад зогсохгүй ирээдүйн амьдралд хэрэгтэй ур чадвар, боловсролыг цогц байдлаар хүлээж авах орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний мэргэжилтэн Х.Энхжаргал: Төсвийн захиран зарцуулалтыг нээлттэй харуулах хэрэгтэй

-Хэлэлцүүлгийн үеэр оролцож байгаа талуудаас таван сэдвийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлуудыг хөндөж байна. Багшийн болон сурагчийн техник технологийн ур чадваруудыг дээшлүүлсэн ажлыг хиймээр байна гэдгийг хэлсэн. Мөн багш нарын ур чадварыг дээшлүүлэхийн тулд заах аргын нэгдлээр дамжуулж багшийг ажлын байранд нь хөгжүүлэх асуудлыг ярьж байна. Түүнчлэн боловсролын санхүүжилттэй холбоотой асуудлаар хэлэлцэхэд дан ганц төсвийн гэхээс илүү төрийн бус



хувийн хэвшлийн санхүүжилттэйгээр шийдэх боломжтой гэсэн санал гарсан. Мөн төсвийн захиран зарцуулалтыг нээлттэй ил тодоор үр дүнг нь тооцдог байхыг хөндөж байна. Суралцагчийн ялгаатай, тэгш хүртээмжтэй байдал, сургалт, орчныг бий болгохыг хүсэлээ.

Хэлэлцүүлгийн үед гарч буй эерэг зүйл нь оролцож байгаа талууд энэ хийх ёстой гэж бусдыг харах биш, энэ асуудлыг шийдэхийн тулд бидний оролцоо юу байна гэсэн асуулт, гаргалгааг хэлж байсан. Нийт таван хэлэлцүүлгийн хүрээнд давхардсан тоогоор 1000 орчим санал гарсан. Үүнээс багш, багшлахуйн мэргэжилтэй холбоотой санал давамгайлж байсан. Жишээ нь, багшийн хандлага, ур чадвар өөрчлөгдөж байж боловсрол өөрчлөгдөнө гэсэн санал гарсан.

Эх сурвалж: "Зууны мэдээ" сонин. 2022 оны Долдугаар сарын 6. ЛХАГВА гараг. № 132 (6864)

"ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ-II" ТӨСӨЛ

Төслийн орон нутгийн хэрэгжүүлэгч байгууллага-БОМСТ



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ СУРГАЛТЫН ТӨВ НҮТБ

Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Элчингийн гудамж

И-мэйл: info@feemongolia.mn
Вэбсайт: feemongolia.mn
Утас: +976 88111893

Үндэсний түшиц байгууллага-БСУХ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Улаанбаатар хот 14191, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-10 Багшийн хөгжлийн ордны 4 давхар

И-мэйл: info@mnier.mn
Вэбсайт: www.mnier.mn
Утас: +976 70129404